



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 11 сарын 06 өдөр

Дугаар А/609

Хэрлэн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2 дугаар зүйлийн 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн цагдаагийн газрын даргаар ажиллаж байсан цагдаагийн хурандаа Э.Жавхлантөгс, аймгийн начин А.Эрдэнэбаяр нарт орон нутгийн зүгээс хүндэтгэл үзүүлэхэд шаардагдах 1,719,500 (нэг сая долоон зуун арван есөн мянга таван зуун) төгрөгийг хавсралтаар баталсугай.

2. Дэмжлэгт шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөц сангийн Засаг дарга хуулиар олгогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбоотой урьдчилан төлөвлөж төсөвт тусгах боломжгүй байсан нэг удаагийн шинжтэй арга хэмжээний зардлаас олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (А.Жаргалсайхан), аймгийн Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Э.Ариунтунгалаг) нарт зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Б.Өнөрцолмонд)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.АЮУРБУНЬ



... ..

... ..

... ..

... ..

... ..

... ..

... ..

... ..

... ..

... ..

... ..

... ..



... ..